**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2024/93/НА-СТА-ТШЗ**



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай сум<br>2024 он | Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын<br>тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 99993365<br>Цахим хаяг: Bat-Undraad@audit.gov.mn<br>Аудитын менежер :Х.Болдбаатар<br>Утас:99105506<br>Цахим хаяг: Boldbaatar.kh@audit.gov.mn<br>Аудитор: Д.Пүүжмаа<br>Утас:99080797<br>Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn: |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
    3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
    3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
    3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
    3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
    4.1 Ерөнхий зүйл
    4.2 Материаллаг байдал
    4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
    4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
    4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
    4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| ***УСНББОУС*** | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ***АДБОУС*** | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ***ЗДТГ*** | Засаг Даргын Тамгын Газар |
| ***ИТХ*** | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.19 № 57

танай ______ -ны № ______ -т

ТҮДЭВТЭЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.БАДАМХАНД-Д

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газар нь Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, бараа материалын тайланг үнэн зөв гаргаагүй, шатахууны зардлыг үрэлгэн зарцуулж, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, жилийн эцсийн тооллогыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1-д "нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна" гэсэн заалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд эзэмшилдээ байгаа 11 газрыг данс бүртгэлд тусгаагүй байна.

**Аудитын гол асуудал**

Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар төсвөөс өвс тэжээлийн нөөцөд өвс худалдан авч борлуулсан ч орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, гэрээгээр гүйцэтгүүлэх

ажлын санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн ч ажил нь хийгдээгүй, цалингийн нэмэгдлийг зөрүүтэй тооцоолж олгосон зэрэг зөрчил илэрсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Шилэн дансны цахим мэдээллийн системд байгууллагын урсгал санхүүжилт, хөрөнгө зарцуулах шийдвэрүүдийг тухай бүр мэдээлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.
Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.
Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **24,987,630.00** | **65,836,880.00** |
| 33 | **АВЛАГА** | **1,315,000.00** | - |
| 335 | Бусад авлага | 1,315,000.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,315,000.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 23,672,630.00 | 65,836,880.00 |
| 354 | Хангамжийн материал | 23,672,630.00 | 56,736,880.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,395,000.00 | 1,737,550.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,625,750.00 | 33,576,450.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 18,651,880.00 | 21,422,880.00 |
| 35600 | Мал амьтад | - | 9,100,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,894,372,831.92** | **1,985,996,206.33** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,894,372,831.92** | **1,985,996,206.33** |
| 392 | Биет хөрөнгө | 1,892,709,491.18 | 1,980,525,282.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,637,321,903.00 | 1,646,372,403.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (152,615,409.91) | (193,870,601.71) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 220,107,300.00 | 309,807,300.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (81,510,156.78) | (100,732,537.50) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 79,011,312.40 | 90,391,312.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (30,164,701.12) | (40,788,048.88) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 32,786,075.00 | 43,676,075.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,988,491.92) | (16,577,791.21) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 290,898,635.93 | 348,768,035.93 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (91,696,675.43) | (108,080,564.69) |
| 39217 | Ном | 1,559,700.00 | 1,559,700.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 1,663,340.74 | 5,470,923.98 |
| 39301 | Програм хангамж | 4,524,500.00 | 9,024,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,861,159.26) | (3,553,576.02) |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,919,360,461.92** | **2,051,833,086.33** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **6,832,350.00** | **6,057,088.76** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **6,832,350.00** | **6,057,088.76** |
| 413 | Өглөг | 6,832,350.00 | 6,057,088.76 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 6,832,350.00 | 6,057,088.76 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,912,528,111.92** | **2,045,775,997.57** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,912,528,111.92 | 2,045,775,997.57 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 507,582,219.61 | 507,582,219.61 |
| 51101 | Өмч: - төрийн | 507,582,219.61 | 507,582,219.61 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,294,615,972.57 | 1,427,863,858.22 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 981,338,210.71 | 1,294,615,972.57 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 313,277,761.87 | 133,247,885.65 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 110,329,919.74 | 110,329,919.74 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,919,360,461.92** | **2,051,833,086.33** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **959,009,147.93** | **841,949,021.20** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **407,403,484.93** | **185,346,400.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 407,403,484.93 | 185,346,400.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 407,403,484.93 | 185,346,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 9,760,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 407,403,484.93 | 175,586,400.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **551,605,663.00** | **656,602,621.20** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | - | 3,500,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 3,500,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 68,907,763.00 | 8,238,321.20 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 68,907,763.00 | 8,238,321.20 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 482,697,900.00 | 644,864,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 482,697,900.00 | 644,864,300.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 563,752,314.86 | 707,386,135.55 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 563,752,314.86 | 707,386,135.55 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 563,520,044.65 | 602,702,272.64 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 216,419,106.80 | 342,872,139.13 |
| 210101 | Үндсэн цалин | 182,044,535.21 | 237,105,944.26 |
| 210102 | Нэмэгдэл | 30,178,851.59 | 100,170,373.31 |
| 210104 | Урамшуулал | 4,195,720.00 | 5,595,821.56 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,914,043.78 | 43,804,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,557,320.18 | 29,096,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,176,127.46 | 4,194,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,740,902.08 | 2,803,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 398,244.49 | 700,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,982,449.57 | 7,008,700.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 59,000.00 | - |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 38,304,466.21 | 27,881,711.96 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,539,216.21 | 3,372,551.96 |
| 210302 | Түлш, халаалт | 34,765,250.00 | 24,509,160.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 92,125,510.00 | 29,601,365.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,145,510.00 | 2,566,540.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,432,800.00 | 16,646,584.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,262,800.00 | 3,262,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 64,214,400.00 | 7,125,441.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,070,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 818,000.00 | 890,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 818,000.00 | 890,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,580,000.00 | 3,999,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,580,000.00 | 3,999,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 31,121,631.00 | 3,404,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,793,631.00 | 2,530,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 232,100.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 469,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,700.00 | 227,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73,800.00 | 73,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 187,000.00 | 103,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 138,300.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 153,237,286.86 | 150,248,656.55 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 78,100,295.00 | 58,412,830.96 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 203,400.00 | 69,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 74,933,591.86 | 91,766,525.59 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **232,270.21** | **104,683,862.91** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 96,191,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 96,191,300.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 232,270.21 | 8,492,562.91 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 232,270.21 | 8,492,562.91 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **395,256,833.07** | **134,562,885.65** |
| 225 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **81,979,071.21** | **-** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 81,979,071.21 | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (81,979,071.21) | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 313,277,761.87 | 134,562,885.65 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| | | | |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **551,605,663.00** | **666,362,621.20** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | - | **9,760,000.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 9,760,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 9,760,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 9,760,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **551,605,663.00** | **656,602,621.20** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | - | 3,500,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 3,500,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 68,907,763.00 | 8,238,321.20 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 68,907,763.00 | 8,238,321.20 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 482,697,900.00 | 644,864,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 482,697,900.00 | 644,864,300.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **492,051,873.00** | **645,772,621.20** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **492,051,873.00** | **645,772,621.20** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **491,819,602.79** | **541,088,758.29** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 215,863,778.58 | 342,872,139.13 |
| 210101 | Үндсэн цалин | 182,413,575.63 | 237,105,944.26 |
| 210102 | Нэмэгдэл | 29,254,482.95 | 100,170,373.31 |
| 210104 | Урамшуулал | 4,195,720.00 | 5,595,821.56 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26,566,800.00 | 43,804,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,163,700.00 | 29,096,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,086,200.00 | 4,194,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,669,400.00 | 2,803,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 416,800.00 | 700,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,230,700.00 | 7,008,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,472,116.21 | 29,516,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,539,216.21 | 3,372,551.96 |
| 210302 | Түлш, халаалт | 27,932,900.00 | 26,143,948.04 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 24,473,800.00 | 19,527,847.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,086,300.00 | 2,792,990.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,124,700.00 | 13,472,057.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,262,800.00 | 3,262,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,817,600.00 | 1,228,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,817,600.00 | 1,228,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,580,000.00 | 3,999,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,580,000.00 | 3,999,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 56,295,303.00 | 8,509,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 54,967,303.00 | 7,535,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 232,100.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 469,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,700.00 | 227,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73,800.00 | 73,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 187,000.00 | 203,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 138,300.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 131,750,205.00 | 91,631,371.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 131,446,805.00 | 91,445,971.96 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 303,400.00 | 185,400.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **232,270.21** | **104,683,862.91** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 96,191,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 96,191,300.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 232,270.21 | 8,492,562.91 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 232,270.21 | 8,492,562.91 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **59,553,790.00** | **20,590,000.00** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **59,553,790.00** | **20,590,000.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **59,553,790.00** | **20,590,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 59,553,790.00 | 20,590,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 59,553,790.00 | 20,590,000.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(59,553,790.00)** | **(20,590,000.00)** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 507,582,219.61 | 213,941,396.41 | 877,726,734.03 | 0.00 | 1,599,250,350.05 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 103,611,476.68 | 0.00 | 103,611,476.68 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **507,582,219.61** | **213,941,396.41** | **981,338,210.71** | **0.00** | 1,702,861,826.73 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | -103,611,476.68 | 0.00 | 0.00 | -103,611,476.68 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 313,277,761.87 | 0.00 | 313,277,761.87 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **507,582,219.61** | **110,329,919.74** | **1,294,615,972.57** | **0.00** | 1,912,528,111.92 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **507,582,219.61** | **110,329,919.74** | **1,294,615,972.57** | **0.00** | 1,912,528,111.92 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **507,582,219.61** | **110,329,919.74** | **1,294,615,972.57** | **0.00** | 1,912,528,111.92 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 133,247,885.65 | 0.00 | 133,247,885.65 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **507,582,219.61** | **110,329,919.74** | **1,427,863,858.22** | **0.00** | 2,045,775,997.57 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН** | 511,845,000.00 | 482,489,097.79 | 674,064,300.00 | 639,874,437.09 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 511,845,000.00 | 482,489,097.79 | 674,064,300.00 | 623,374,437.09 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 511,845,000.00 | 482,489,097.79 | 577,873,000.00 | 527,183,137.09 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 216,034,100.00 | 215,863,778.58 | 350,433,000.00 | 342,872,139.13 |
| 210101 | Үндсэн цалин | 216,034,100.00 | 182,413,575.63 | 261,122,800.00 | 237,105,944.26 |
| 210102 | Нэмэгдэл | - | 29,254,482.95 | 89,310,200.00 | 100,170,373.31 |
| 210104 | Урамшуулал | - | 4,195,720.00 | - | 5,595,821.56 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,566,800.00 | 26,566,800.00 | 43,804,200.00 | 43,804,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,065,400.00 | 18,163,700.00 | 29,786,800.00 | 29,096,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,125,400.00 | 2,086,200.00 | 3,504,300.00 | 4,194,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,700,300.00 | 1,669,400.00 | 2,803,500.00 | 2,803,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 425,100.00 | 416,800.00 | 700,900.00 | 700,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,250,600.00 | 4,230,700.00 | 7,008,700.00 | 7,008,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,476,700.00 | 31,472,116.21 | 29,516,500.00 | 29,516,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,543,800.00 | 3,539,216.21 | 4,777,200.00 | 3,372,551.96 |
| 210302 | Түлш, халаалт | 27,932,900.00 | 27,932,900.00 | 24,739,300.00 | 26,143,948.04 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,746,300.00 | 23,766,600.00 | 18,973,500.00 | 18,973,434.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,086,300.00 | 2,086,300.00 | 2,793,000.00 | 2,792,990.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,397,200.00 | 18,417,500.00 | 12,917,700.00 | 12,917,644.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,262,800.00 | 3,262,800.00 | 3,262,800.00 | 3,262,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,217,600.00 | 13,217,600.00 | 1,228,200.00 | 1,228,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11,400,000.00 | 11,400,000.00 | - | - |
| 210604 | Урсгал засвар | 1,817,600.00 | 1,817,600.00 | 1,228,200.00 | 1,228,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,580,600.00 | 3,580,000.00 | 3,161,200.00 | 3,279,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,580,600.00 | 3,580,000.00 | 3,161,200.00 | 3,279,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 79,052,100.00 | 58,295,303.00 | 15,388,000.00 | 8,509,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 77,692,000.00 | 56,967,303.00 | 13,700,000.00 | 7,535,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 232,100.00 | 232,100.00 | 560,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 469,100.00 | 469,100.00 | 469,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,700.00 | 227,700.00 | 227,700.00 | 227,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73,800.00 | 73,800.00 | 73,800.00 | 73,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 203,400.00 | 187,000.00 | 203,400.00 | 203,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 138,300.00 | 138,300.00 | 138,300.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15,700.00 | - | 15,700.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 118,170,800.00 | 109,726,900.00 | 115,368,400.00 | 79,000,163.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 117,867,400.00 | 109,423,500.00 | 115,065,000.00 | 78,814,763.96 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 303,400.00 | 303,400.00 | 303,400.00 | 185,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - | 96,191,300.00 | 96,191,300.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - | 96,191,300.00 | 96,191,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | - | 96,191,300.00 | 96,191,300.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** | **-** | **16,500,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | - | - | 16,500,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | - | - | 16,500,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 511,845,000.00 | 482,489,097.79 | 557,184,300.00 | 648,364,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 511,845,000.00 | 482,489,097.79 | 557,184,300.00 | 648,364,300.00 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 511,845,000.00 | 482,489,097.79 | 557,184,300.00 | 648,364,300.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **17,995,621.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **17,995,621.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 17,995,621.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 554,413.20 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 554,413.20 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 0.00 | 720,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 720,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 16,721,208.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 16,721,208.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **0.00** | **2,700.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 2,700.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 8,238,321.20 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 8,238,321.20 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 8,238,321.20 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Түдэвтэй сумын ЗДТГ нь харьяалагдах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр төсөл зохиох, зохицуулах,хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын тасаг албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны удирдлагыг мэдээллээр хангах үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

“Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх сум орон нутгаа хөгжүүлэх” гэсэн зорилгыг тавин ажиллаж байна.

2023 онд Түдэвтэй сумын ЗДТГ-аас “Иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх” гэж дэвшүүлсэн зорилтын хүрээнд үйл ажиллагааныхаа чиглэлийг тодорхойлж,7 зорилтын хүрээнд 110 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 90.9 хувиар дүгнүүлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Түдэвтэй сумын ЗДТГ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, зэрэг хуулиудыг голлон мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлээр  дараах хууль, журамд өөрчлөлт орсон байна.

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй  байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түдэвтэй сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Түдэвтэй сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 132.4 сая төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 23,672.6 | 65,836.9 | 42,164.3 |
| Үндсэн хөрөнгө | 1,894,372.8 | 1,985,996.2 | 91,623.4 |
| **Нийт хөрөнгө** | **1,919,360.5** | **2,051,833.1** | **132,472.6** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,912,528.1 | 2,045,776.0 | 133,247.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,919,360.5** | **2,051,833.1** | **132,472.6** |

Бараа материал дансны үлдэгдэл 42.1 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 81.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч, сумын ОНХС-ын хөрөнгөөр 17,3 сая төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 56.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны хувьд Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт болон аймаг,сумын ОНХС-ын хөрөнгөөр 154.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч өгсөн, мөн өөрийн хөрөнгөөр 25.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэснээс шалтгаалж 132.4 сая төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын дансны үлдэгдэл 2,051.8 сая төгрөг болж 133.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй  холбоотой байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 698.6 сая , нийт зарлагыг 698.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг батлахдаа өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн, 113.6 сая төгрөгөөр бууруулан 585.0 сая төгрөгөөр баталжээ. 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 07 тоот тогтоолоор сумын ИТХ-аар төсвийг тодотгон 81.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 666.1 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 666.1 сая төгрөгийн төсөв батлсны 636.6 сая орон нутгийн төсвөөс, дээд шатны төсөв захирагчаас 29.5 төгрөгийн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 618.8 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 29.5 сая төгрөг авч, нийт 639.8 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж, 8.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 639.8 сая төгрөг буюу 98.6 хувьтай байна.Зардлын гүйцэтгэл дутуу байгаа нь тайлант онд цалиг хөлс, нэмэгдэл урамшлыг 7.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн 6.9 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал | 361,366.3 | 433,574.0 | 72,207.6 | -120.0 |
| 2 | 80106-Багийн үйл ажиллагаа | 87,741.7 | 88,787.3 | 1,045.6 | -101.2 |
| 3 | 81102- Засаг даргын нөөц сан | 94,200.0 | 59,737.8 | 34,453.2 | 63.4 |
| 4 | 81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх | 20,865.0 | 20,864.9 | 36.0 | 100 |
| 5 | 80205 Мэдээлэл сурталчилгааны зардал | 13,700.0 | 13,700.0 | 0 | 100 |
| 6 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 96,191.3 | 96,191.3 | 0 | 100 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд шилдэг сумын шагнал 4.9 сая, үлийн цагаан оготно устгалын устгалын зардал 7.2 сая, хагас жилийн мал тооллогын зардал 0.9 сая, Алсын хараа 2050-ын томилолтын зардал 1.1 сая, бусад эх үүсвэрээс 3.9 сая, нийт 18.0 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 16.7 сая, хангамжийн бараа материалын бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 33.6 сая, худгийн гэрэл, цахилгаан зардалд 3.2 сая бусад зардалд 3.6 сая төгрөгийг зарцуулж, 20,9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллагад тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Түдэвтэй сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Пүүжмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түдэвтэй сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/17 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 554.9 сая төгрөгийн 1.5 хувь буюу 8.3 сая сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажилласныг шалгахад Улаанбаатар хотод амьдарч байгаа нутгийн иргэддээ 5.0 сая төгрөгөөр хүндэтгэл үзүүлсэн, дууны дурсгалын цогцолбор байгуулахад төсвөөс 1.0 сая, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2.0 сая төгрөгийн сурталчилгаа хийсэн зэрэг зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6."үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх",13 дугаар зүйлийн 13.3.1."хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах", 15 дугаар зүйлийн

15.1.4."Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг шалгахад тайлант хугацаанд оруулах ёстой мэдээллийг бүрэн байршуулсан байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа зөрчил илрээгүй.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Түдэвтэй сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудитыг хийгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | **1** | **900,0** | **1** | **900,0** | **100** |
| Албан шаардлага | 7 | 495,449,5 | 7 | 454,398,9 | 97.4 |
| Зөвлөмж | 6 | 49,793,8 | 6 | 47,007,0 | 96.7 |
| **Нийт дүн** | **14** | **546,143.4** | **14** | **502,305.9** | **98.0** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.**

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4.5 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 4.5 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд:Санхүүгийн тайланд 4.5 сая төгрөгийн үнэтэй программыг данс бүртгэлд тусгаагүй байсныг аудитын явцад залруулан бүртгэлд тусгууллаа.

Аудитаар нийт 68.3 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 48.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 20.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

### 5.1 Төлбөрийн акт

*Илрүүлэлт:* Төсвөөс өвс тэжээлийн нөөцөд өвс худалдан авч иргэдэд хөнгөлөлттэй үнээр борлуулсан ч, 3.5 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, 04 агаарын шугам хийх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр 15.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн ч ажил нь хийгдээгүй,түр томилогдсон албан тушаалтанд 1.4 сая төгрөгийн зэрэг дэвийн нэмэгдэл бодож олгосон,тагнуулын байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамрагдаагүй байхад нууц хамгаалах ажилтанд 965.4 сая төгрөгийн нэмэгдлийг олгосон нь:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2."батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.6."төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх",

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.3."Төрийн захиргааны ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг Монгол Улсын сайд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын ерөнхий прокурор, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын Агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус шийдвэрлэнэ", Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Монгол улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 2.1."Тагнуулын байгууллагын саналыг авсны үндсэн дээр байгууллага өөрийн бүтэцдээ нууц хамгаалах нэгж байгуулах, өөрчлөх, татан буулгах, эсхүл орон тооны ажилтан томилох шийдвэрийг гаргана" гэж заасантай нийцэхгүй байна.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.2 Албан шаардлага

*Илрүүлэлт:* Сумын Эрүүл мэндийн төвд өндөр хурдны интернет 3.5 сая төгрөгөөр худалдан авсан, Улаанбаатар хотод амьдарч байгаа нутгийн иргэддээ 5.0 сая төгрөгөөр хүндэтгэл үзүүлсэн, багуудад 10.9 сая төгрөгөөр гэр худалдан авсан, татвар төлөгчдийн өдрийг 2.5 сая төгрөгөөр тэмдэглэн өнгөрүүлсэн, дууны дурсгалын цогцолбор байгуулахад төсвөөс 1.0 сая төгрөг зарцуулсан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2.0 сая төгрөгийн сурталчилгаа хийсэн, шатахууныг үрэлгэн зарцуулж, 20.2 сая төгрөгийн жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, эрх бүхий албан тушаалтны 1.9 сая төгрөгийн нэмэгдлийг тооцож олгохдоо хэдэн хувиар авахыг тушаал шийдвэрт тусгаагүй, Улс төрийн албан тушаалтанд 1.0 сая төгрөгийн урамшуулал олгосон,Газрын цахим мэдээллийн системд бүртгэлтэй байгаа 11 газрын, гэрчилгээ, бичиг баримтыг холбогдох газруудаар гаргуулж данс бүртгэлд тусгаагүй, бараа материалын тайланг үнэн зөв гаргаагүй, жилийн эцсийн тооллогыг зохион байгуулаагүй зэрэг нь:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2."батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1."улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлээс", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.6."үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх",13.3.1."хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах", 15.1.4."Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх",
Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1."Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 12 дугаар зүйлийн 12.2."Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1."жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны Жишиг норм батлах тухай 390 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны “Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Программыг данс бүртгэлд тусгаагүй | 1 | 4,500.0 | 1 | 4,500.0 | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **4,500.0** | **1** | **4,500.0** | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

**/мянган төгрөгөөр/**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс Төлбөрийн акт | | Үүнээс Албан шаардлага | | Үүнээс Зөвлөмж | | Үүнээс Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Үүнээс Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Түдэвтэй сумын ЭМТ-д өндөр хурдны интернет худалдан авч өгч үрэлгэн зарцуулсан | 1 | 3,500.0 | | | 1 | 3,500.0 | | | | | | |
| ЗД-ын нөөц хөрөнгөөс нутгийн иргэдэд хүндэтгэл үзүүлсэн | 1 | 5,000.0 | | | 1 | 5,000.0 | | | | | | |
| Багуудад гэр худалдан авч үрэлгэн зарцуулсан | 1 | 10,890.0 | | | 1 | 10,890.0 | | | | | | |
| Татвар төлөгчдийн өдрийг зохион байгуулж төсвөөс үрэлгэн зарцуулсан | 1 | 2,500.0 | | | 1 | 2,500.0 | | | | | | |
| Дууны дурсгал цогцолбор байгуулахад | 1 | 1,000.0 | | | 1 | 1,000.0 | | | | | | |
| Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийж төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн | 1 | 2,000.0 | | | 1 | 2,000.0 | | | | | | |
| ЗДТГ-ын үндсэн хөрөнгө дээр газрыг бүртгээгүй /нийт 11 ш газар/ | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| Бараа материалын тайланг үнэн зөв гаргаагүй | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| Жилийн эцсийн тооллого зохион байгуулаагүй | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шатахууныг үрэлгэн зарцуулж,жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй | 1 | 20,212.3 | | | 1 | 20,212.3 | | | | | | |
| ЭБАТ-ы нэмэгдлийн хувийг тушаал дээр хэдээр авахыг заагаагүй 30 хувь | 1 | 1,916.0 | | | 1 | 1,916.0 | | | | | | |
| Улс төрийн албан тушаалтанд урамшуулал олгосон | 1 | 965.0 | | | 1 | 965.0 | | | | | | |
| 04 агаарын шугам хийх ажлыг гэрээгээр нүйцэтгүүлэхээр санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн ч ажил нь хийгдээгүй | 1 | 15,000.0 | 1 | 15,000.0 | | | | | | | | |
| Түр томилогдсон албан тушаал дээр зэрэг дэвийн нэмэгдэл бодож олгосон | 1 | 1,405.4 | 1 | 1,405.4 | | | | | | | | |
| Нууцын нэмэгдлыг Тагнуулын шалгалтад ороогүй олгосон | 1 | 958.2 | 1 | 958.2 | | | | | | | | |
| Өвс тэжээлийн нөөцөд өвс худалдан авч иргэдэд борлуулж, борлуулсан орлогыг төсөвт төвлөрүүлээгүй | 1 | 2,987.0 | 1 | 2,987.0 | | | | | | | | |
| Сөрөг санал дүгнэлт авсан учир | 1 | 0 | | | | | | | 1 | 1 | | |
| **Дүн** | **17** | **68,334.3** | **4** | **20,350.6** | **12** | **47,983.7** | | | **1** | **1** | | |

**БОЛОВСРУУЛСАН :** АУДИТОР Д.ПҮҮЖМАА 2024.02.20

**ХЯНАСАН**:

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР 2024.02.21

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА 2024.02.21